



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/281

Булган сум

### Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.8, 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Нийтийн номын сангийн барилгыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ХХII/03 дугаар тогтоолоор акталж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барих болсонтой холбогдуулан тус номын сангийн үйл ажиллагааг 2024 оны 04 дүгээр сарын 25-аас 2025 оны 04 дугаар сарын 24-ны өдрийг дуустал “Хуримт итгэлт” ХХК-ны 97,6 мкв талбай бүхий барилгад шилжүүлэн, үйл ажиллагааг стандартын шаардлагад нийцүүлэн явуулахыг Нийтийн номын сангийн захирал (Т.Мөнгөнтуяа)-д үүрэг даалгасугай.

2. “Хуримт итгэлт” ХХК-ны барилгын түрээсийн төлбөрийг сарын 1,655,000 (нэг сая зургаан зуун тавин таван мянга) төгрөгөөр тооцож, түрээсийн гэрээ байгуулан, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

3. Тус Нийтийн номын сангийн барилгын түрээсийн зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

